

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF COURT DECISION EXECUTION AND LEGAL REGULATION OF ADMINISTRATIVE CASES IN THE LAW ON ENFORCEMENT OF COURT DECISIONS



Б.Мөнгөннахиа

*Санхүү эдийн засгийн их сургуулийн,
Эрх зүйн тэнхимийн ахлах багш,
хуульч, өмгөөлөгч, хууль зүйн магистр.*



Э.Цэрэнханд

*Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш,
хууль зүйн магистр, хошууч*

Товч утга: Тус өгүүлэлдээ захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудлыг хөндөн судлалаа.

Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны шийдвэр гүйцэтгэл, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны хэргийн шүүх, иргэний хэргийн шүүх

Abstract: In this article, we aim to analyze and evaluate the newly approved law on the enforcement of court decision. It is also the article examines the theory and practice of enforcement of administrative decision and enforcement of administrative court decision.

Keywords: Enforcement of court decisions, enforcement of administrative decision, enforcement of administration court decision, administrative court, civil court

Захиргааны эрх зүйд захиргааны байгууллагын шийдвэрийг биелүүлэх болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гэсэн хоёр ойлголт байдаг. Захиргааны байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны ерөнхий хуулиар зохицуулагдах бол захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулагдаж байна.

1. Захиргааны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийн тухай

Захиргааны байгууллагаас өдөр бүр иргэдэд хандан ямар нэг үйлдэл хийхийг даалгасан, хориглосон агуулга бүхий шийдвэрийг гаргаж байдаг. Энэхүү шийдвэрийг хүн, хуулийн этгээд биелүүлээгүй бол захиргааны байгууллага гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг өөрөө хариуцан гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас тусдаа захиргааны байгууллагаас өөрийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэх тухай ойлголт юм.

Захиргааны шийдвэр гүйцэтгэл хэмээх ойлголтод захиргааны байгууллагаас гаргасан захиргааны актыг албадан гүйцэтгэхийг ойлгоно.³⁹ Захиргааны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийн нийтлэг зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуулийн 8-р бүлэгт хуульчилсан байна. Харин энд захиргааны шийдвэр гүйцэтгэлийн тухай ойлголтын албан ёсны тодорхойлолтыг хуульчлаагүй ба судлаач П.Одгэрэл “Захиргааны шийдвэр гүйцэтгэл гэж захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн хүрээнд гаргасан хаяглагдсан этгээдэд сөрөг нөлөөтэй үүрэг даалгавар бүхий шийдвэрийг тухайн этгээд сайн дураараа биелүүлээгүй бол түүнийг захиргааны байгууллагаас хариуцан албадан гүйцэтгүүлэх ажиллагааг ойлгоно”⁴⁰ гэж тодорхойлоод энэхүү тодорхойлолтын дагуу дараах үндсэн шинж бүхий ажиллагаа захиргааны шийдвэр гүйцэтгэлд хамаарна гэжээ.

- Захиргааны байгууллагын шийдвэр,
- Нийтийн эрх зүйн хүрээнд гарсан,
- Уг шийдвэрээр дарамт бүхий үүргийг иргэдэд даалгасан,
- Даалгасан үүргийг сайн дураараа биелүүлээгүй бол,
- Захиргааны байгууллага албадан гүйцэтгүүлнэ.⁴¹

Дээрхээс үзвэл иргэн, захиргааны байгууллага буюу төрийн хүсэл зоригийн эсрэг байж даалгасан үүрэг даалгаврыг сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд л албадлагын аргаар хэрэгжүүлэх үр дагавар үүсэж байна.

Захиргааны шийдвэр гүйцэтгэхдээ хэрэглэх албадлага нь Захиргааны ерөнхий хуульд зааснаар:

³⁹ Д.Сүнжид “Захиргааны ерөнхий хууль: үзэл баримтлал, хэрэглээ” УБ., 2017 он. 90 дэх тал

⁴⁰ П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” УБ., 2016 он. 330 дахь тал.

⁴¹ Мөн тэнд

- Торгууль ногдуулах,
- Бусдаар гүйцэтгүүлэх,
- Албадан гүйцэтгэх гэсэн хэлбэртэй байна. Эдгээр хэлбэрийн тухай

товч авч үзье.

Захиргааны шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй бол торгууль ногдуулна. Энэ нь зөвхөн мөнгөн шаардлага бүхий захиргааны акт төдийгүй тодорхой үйл ажиллагаа хийхийг даалгах, эсхүл тодорхой үйл ажиллагаа хийхийг зогсоох зэрэг агуулга бүхий захиргааны шийдвэрийн тухайд хэрэглэж болно. Торгууль оногдуулах хэмжээ, нөхцөл нь зөрчлийн тухай хууль⁴², зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль⁴³ холбогдох бусад хуультай нийцсэн байх шаардлагатай.

Бусдаар гүйцэтгүүлэх албадлага хэрэглэхийг ЗЕХ-ийн 86.1.2, 88-р зүйл хуульчилсан байна. Энэ арга нь мөнгөн шаардлага бүхий захиргааны актын хувьд хэрэглэхгүй. Харин тодорхой үйл ажиллагааг хийх үүрэг хүлээсэн этгээд түүнийг хийгээгүй бөгөөд бусад этгээдээр уг ажлыг хийлгэх боломжтой бол захиргааны шийдвэр гүйцэтгэх байгууллага тухайн этгээдээр хийлгэж, гарсан зардлыг үүрэг хүлээсэн этгээдээс гаргуулан ажил гүйцэтгэсэн этгээдэд олгоно.

Албадан гүйцэтгэх аргыг ЗЕХ-ийн 86.1.6, 89-р зүйлд хуульчилсан байдаг. Дээрх 2 захиргааны шийдвэр гүйцэтгэх арга нь зорилгодоо хүрээгүй, эсхүл энэ хоёр аргыг хэрэглэх боломжгүй агуулга бүхий захиргааны актын тухайд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албадан гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулна. Захиргааны ерөнхий хуульд заасан албадан гүйцэтгэх арга хэрэгсэл нь хүний болон эд юмст биеийн эсхүл бусад арга хэрэгслийн тусламжтайгаар халдахыг ойлгодог. Энэ арга нь хүний бие, эд юманд халддаг учир холбогдох хуульд заасан журмын дагуу явагдах учиртай.

Албадлага хэрэглэх дээрх гурван арга хэрэгслийн нэгийг сонгож, гарсан захиргааны актыг уг захиргааны актыг батлан гаргасан байгууллага, дээд шатны захиргааны байгууллагын актын тухайд анхан шатны нэгжээс, эсхүл тусгайлан хуулиар эрх олгосон байгууллага болон цагдаагийн байгууллагаас туслалцаа авч хэрэгжүүлнэ.⁴⁴

Захиргааны ерөнхий хуулийн 84.2-т захиргааны байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тухайн салбарын хуульд заасан эрх хэмжээний дагуу, хуульд заасан журмаар албадлага хэрэглэх эрхтэй. Тухайлбал, татварын байцаагч, цагдаагийн албан хаагч, шийдвэр гүйцэтгэгч зэргийг ойлгоно. Захиргааны

⁴² Зөрчлийн тухай хууль 3.4-р зүйл., УБ. 2017.05.11

⁴³ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль., УБ. 2017.05.18

⁴⁴ Захиргааны ерөнхий хууль 84.1-р зүйл

шийдвэрийг гүйцэтгэх байгууллагаас ЗЕХ-ийн 83.1.3, 83.1.4⁴⁵, 85.1⁴⁶-д заасан мэдэгдэл дэх хугацаанд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд захиргааны шийдвэр гүйцэтгэх албадлага хэрэглэх тухай шийдвэр гаргана. Энэ шийдвэрт захиргааны шийдвэр гаргах ажиллагааны журам үйлчлэхгүй ч гомдол гаргах журам үйлчилдэг.

Харин захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай доор дурдъя.

1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршино.⁴⁷

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр бүрэн гүйцэд биелэгдэж байх нь эрх зүйн соёл, ухамсрын түвшин харилцан адилгүй олон нийтийн зүгээс захиргааны хэргийн шүүхийг хүлээн зөвшөөрөхөд чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс шууд хамааралтай байх онцлогтой.⁴⁸

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг Монгол Улсын Үндсэн хууль⁴⁹, шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль⁵⁰, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15-р бүлэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд зохицуулдаг. Харин захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд эрүүгийн хууль, зөрчлийн хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, төрийн албаны тухай хууль, захиргааны хэрэг

⁴⁵ Захиргааны ерөнхий хуулийн 83.1.3 “83.1.3.хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх бүхий шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн байх”, 83.1.4 “үүрэг хүлээгчид 14 буюу түүнээс доошгүй хоногийн хугацаанд захиргааны шийдвэрийг биелүүлэх тухай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн байх”

⁴⁶ Захиргааны ерөнхий хуулийн 85.1 “Албадлагыг хуульд зааснаар нэн даруй хэрэглэхээс бусад тохиолдолд албадлага хэрэглэх тухай мэдэгдлийг үүрэг хүлээгчид бичгээр өгөх бөгөөд уг мэдэгдэлд үүрэг биелүүлэх хугацааг заана.”

⁴⁷ А.Дугармаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудал” илтгэл

⁴⁸ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхыг бэхжүүлэх” төсөл. 2016 он.

⁴⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2 “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”, 19.1 “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, 16.14 “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах...”

⁵⁰ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.10 “шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээлэлд хяналт тавьж, холбогдох байгууллагад шаардлага тавих”

шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16-р бүлэг болон хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, мөн эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас байдаг. Шүүхийн хүчин төгөлдөр болсон эцсийн шийдвэрийг хэргийн оролцогчид сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд албадан биелүүлэх шаардлага бий болдог.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр дагавар нь бусад шүүхийн шийдвэрээс зарим талаараа өвөрмөц байдаг. Учир нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь нэхэмжлэгч, хариуцагчаас гадна гуравдагч этгээд буюу олон нийтэд хамааралтай байдаг. Шүүх хэргийг хянан үзээд ЗХШХШТХуульд заасан 14 төрлийн⁵¹ шийдвэр гаргах бөгөөд ямар төрлийн шийдвэр гаргахаас хамаарч, шүүхийн шийдвэрийг биелүүлэх арга, журам өөр өөр байна.

Захиргааны хэргийн шүүхээс гаргаж байгаа шийдвэрүүдийг тоймлон авч үзвэл дараах төрлүүдтэй байна. Үүнд:

1. Захиргааны акт, захиргааны гэрээ хууль бус болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох
2. Захиргааны акт, захиргааны гэрээ нь илт хууль бус болохыг тогтоох
3. Захиргааны акт хууль бус болохыг тогтоох
4. Захиргааны акт даалгахыг даалгах, эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоох
5. Төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг өөрчлөх
6. Захиргааны акт хүчин төгөлдөр бус болохыг тогтоох
7. Захиргааны акт илт хууль бус болохыг тогтоох
8. Захиргааны шинэ акт гарах хүртэл хугацаагаар захиргааны актыг түдгэлзүүлэх
9. Шүүхийн зардал тогтоосон захирамж

Дээрх шүүхийн шийдвэрээс шалтгаалан хэрэгжүүлэх арга журам, албадлагын арга хэмжээг сонгон хэрэглэхэд ялгаатай байдаг. Тухайлбал ЗХШХША-г дотор нь төлөөлөн гүйцэтгэж болох ба төлөөлөн гүйцэтгэж болохгүй ажиллагаа гэж ангилдаг. Захиргааны зохих акт гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрийг зөвхөн тухайн захиргааны актыг гаргах эрх бүхий захиргааны байгууллага, албан тушаалтан л гаргах замаар биелүүлэхээс, өөр хэн нэгэн уг захиргааны актыг гаргах эрхгүй тул төлөөлүүлэн гүйцэтгэх боломжгүй юм.⁵²

⁵¹ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.,106.3-р зүйл.

⁵² А.Эрдэнэцогт “Монгол улсын захиргааны процессын эрх зүй” УБ., 2014 он. 323 дахь тал.

Захиргааны хэргийн шүүхийн зорилго нь иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалахад чиглэдэг тул шийдвэр гүйцэтгэл нь энэ зорилгыг хангахад оршино.⁵³

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа хариуцагчид шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлнэ. Энэхүү мэдэгдэх хуудаст шүүхийн шийдвэрийн агуулга, шаардлага, түүнийг биелүүлэх хугацаа, шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх хугацаа, албадлага хэрэглэх арга журмын талаар тодорхой тусгасан байна. Хариуцагч мэдэгдэх хуудаст заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр түүнд нийцүүлэн олгосон гүйцэтгэх хуудсыг үндэслэн явуулдаг.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг үндэслэн шууд гүйцэтгэх хуудас олгох болон нэхэмжлэгчийн хүсэлтээр гүйцэтгэх хуудас олгох нөхцөлийг тус тус заасан байна. Нэхэмжлэлийн агуулга, гүйцэтгэх үүргээс хамааран шууд олгох гүйцэтгэх хуудсыг дараах байдлаар тодорхойлно⁵⁴.

1. Нэхэмжлэгчийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай
2. Ажлаас үндэслэлгүй халсан, чөлөөлсөн, шилжүүлсний нөхөн олговор олгуулах тухай
3. Захиргааны актыг түдгэлзүүлэх тухай
4. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацаанаас хамаарч хүн, хуулийн этгээдэд ноцтой хохирол учрахаар бол түүний хүсэлтээр
5. Хуульд заасан бусад /бусдын амь бие, эрүүл мэндэд учирсан хохирол/ үндэслэлээр гэж заасан.

Дээрх үндэслэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст гүйцэтгэх баримт бичгийг шууд хүргүүлэхээр, бусад тохиолдолд шийдвэр гаргасан шүүхэд нэхэмжлэгч хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг гаргаж, нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн гүйцэтгэх хуудсыг олгосноор шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсын хамт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ирүүлнэ. Ийнхүү ирүүлсэн гүйцэтгэх баримт бичгийг агуулгын болон хэлбэрийн шаардлага хангаж байгаа эсэхийг ахлах шийдвэр гүйцэтгэгч хянаж, 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэх

⁵³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхыг бэхжүүлэх” төсөл. УБ., 2016 он.

⁵⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24

ажиллагааг үүсгэх, эсхүл гүйцэтгэх хуудас олгосон шүүхэд буцаах асуудлыг шийдвэрлэнэ. Хууль зүйн шаардлага хангасан гүйцэтгэх баримт бичгийг ахлах шийдвэр гүйцэтгэгч үүсгэх тогтоол үйлдэн шийдвэр гүйцэтгэгчид хуваариалан олгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлнэ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлсэн байх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх, хугацаатай мэдэгдэл хүргүүлэх, албадан биелүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох гэсэн 5 үе шаттай байна.⁵⁵

Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь өөрийн онцлогийг харуулсан хэд хэдэн өвөрмөц зохицуулалтуудтай. Эдгээр зохицуулалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилттэй харьцуулан авч үзвэл:

1. Бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар нь доод шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтэд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж, харилцан хамтран ажиллана.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хугацаанд захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг Засгийн газарт, Улсын Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна гэжээ. Дээрх 2 зохицуулалтаас харахад төрийн байгууллагууд шүүхийн шийдвэрийн биелэлтэнд тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлж хамтран ажиллах боломжтой талаар тусгасан байна. Харин дээрх 2 ойлголтоор шүүхийн шийдвэр биелүүлээгүй албан тушаалтны мэдээллийг “...Засгийн газар болон Улсын их хуралд танилцуулна” гэж хэт ерөнхий зохицуулсан нь танилцуулаад тэндээс хэрхэн уг асуудлыг шийдвэрлэх, хариуцлага тооцох эсэх талаарх үндсэн ойлголтыг орхигдуулсан зохицуулалт болжээ.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132.2-т “Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа, эсхүл ШШГТХ-д заасны дагуу нэмэлт хугацаа тогтоосон бол тухайн хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн

⁵⁵ “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” гарын авлага. УБ., 2004 он.

шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ” гэжээ.

4. Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөл болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

5. “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэсэн нь төрийн байгууллагын алба хаагчийн буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирол, төлбөрт анхаарал хандуулсан асуудал болохоос албан тушаалтны буруутай шийдвэр түүнийг хянах, нэгдсэн зохион байгуулалтаар үүний эсрэг арга хэмжээ авах талаар ойлголтыг агуулаагүй байна.

Дээрх зохицуулалтуудаас үзвэл захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн хамгааллын механизм бүрэлдсэн тогтсон гэж үзэх боломжтой байна.

Гэвч төрийн албан хаагчийн эрх, үүргийг нийтлэг байдлаар тодорхойлсон Төрийн албаны тухай хуульд энэ төрлийн харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүй байна. Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах талаар зохицуулалт байх хэдий ч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд хэрхэн, ямар төрлийн сахилгын шийтгэл, арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар зохицуулалт байхгүй байна.

Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх⁵⁶ зорилготой Монгол Улсын зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” гэдэг ойлголтонд захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн тохиолдолд авах арга хэмжээг огт хуульчлан тогтоож өгөөгүй байна.

Үүнээс үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага хэт ерөнхий бөгөөд явцуу байгаа нь харагдаж байна.

“Хариуцагч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ тухай олон нийтэд мэдээлж, шаардлагатай бол биелүүлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно” хэмээн

⁵⁶ Зөрчлийн тухай хууль. 2017

зохицуулсан боловч Шийдвэр гүйцэтгэх албанд төлбөр төлөгчийн төлбөрөө төлөөгүй болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээллэсэн талаар тоон баримт, судалгаа өнөөдрийн байдлаар байхгүй байна. Энэ нь энэ төрлийн арга хэмжээг хэрэглэж хэвшээгүй байгааг илэрхийлж байгаа хэрэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-т “Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч-хуулийн этгээдийн дансанд байгаа төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна” гэж хуульчилсан. Төлбөр төлөгч-улсын төсвийн байгууллагууд нь хохирол, төлбөр төлөх зориулалт бүхий төсөвлөсөн мөнгөн хөрөнгөгүй, Төсвийн тухай хуульд зааснаар Төрийн сангийн газраас мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийж, санхүүгийн бүртгэл хөтөлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөр төлөгч-улсын төсвийн байгууллагын данс битүүмжлэх, суутгал хийх, балансад бүртгэлтэй хөрөнгөөс төлбөр гаргуулах боломжгүйгээс 2008 оноос хойш тухайн жилийн төсөвт шүүхийн шийдвэрт заасан төлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тусгуулж, хохирол, төлбөрийг барагдуулж байна. Төрийн байгууллага, алба хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008-2023 оны төсөвт тусгагдсан мөнгөн хөрөнгөөс шүүхийн шийдвэрийг үндэслэн 72.6 тэрбум төгрөгийг төлбөр авагч иргэн, хуулийн этгээдэд олгосон⁵⁷ байна.

⁵⁷ Төлбөр төлөгч- төсвийн байгууллагад холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааны танилцуулга. 2023.03.31. ШГА. ШШГЕГ


Хүснэгт 1. Төрийн байгууллага, албан тушаалтнаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн судалгаа

Д/д	Он	Тушаалаар олгогдсон дүн		Үүнээс:			
		Гүйцэтгэх хуудас	Мөнгөн дүн /мян.төг/	Иргэнд		Хуулийн этгээдэд	
				Гүйцэтгэх хуудас	Мөнгөн дүн /мян.төг/	Гүйцэтгэх хуудас	Мөнгөн дүн /мян.төг/
1	2008	16	183,187.2	16	183,187.2		
2	2009	132	3,399,998.8	76	543,179.9	56	2,856,818.9
3	2010	83	1,000,000.0	41	333,002.6	42	666,997.4
4	2011	65	11,694,533.0	30	229,380.0	35	11,465,153.0
5	2012	240	12,006,569.3	165	4,284,067.7	75	7,722,501.6
6	2013	61	6,700,959.7	46	542,318.9	15	6,158,640.8
7	2014	31	4,953,073.0	25	796,265.3	6	4,156,807.7
8	2015	74	2,247,800.9	70	1,640,817.3	4	606,983.6
9	2016	69	2,374,305.0	60	1,945,451.5	9	428,853.5
10	2017	04	15,115,191.8	299	5,625,680.5	105	9,489,511.3
11	2018	11	2,362,776.7	187	1,367,357.2	24	995,419.5
12	2019	00	2,428,192.4	99	2,073,255.9	1	354,936.5
13	2020	113	2,280,547.7	61	607,864.5	52	1,672,683.2
14	2021	153	2,280,486.7	124	1,329,320.2	29	951,166.5
15	2022	102	1,916,608.8	98	1,332,712.4	4	583,896.4
16	2023	87	1,657,630.1	41	790,763.7	46	866,866.4
Нийт		1941	72,601,861.1	1,438	23,624,624.8	503	48,977,236.3

Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 1 дүгээр улирлын мэдээгээр нийт ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн 74 хувийг иргэний, 19 хувийг эрүүгийн, 6 хувийг бусад, 1 хувийг захиргааны хэргийн гүйцэтгэх баримт бичиг эзэлж байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт нь 7 жилийн дунджаар авч үзэхэд 59 хувьтай биелэгдэж байна.

График 1. 2023 оны ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн судалгаа

2023 ОНЫ АЖИЛЛАГААНД БАЙГАА ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧИГ



■ Иргэний хэрэг ■ Захиргааны хэрэг ■ Эрүүгийн хэрэг ■ Бусад хэрэг

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бодит биелэлтийн тухайд иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас урт хугацаа шаардагдсан ажиллагаа байсаар ирсэн.

Үүнд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйлд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд нь нэг талдаа төрийн байгууллага, албан тушаалтан оролцож байгаад оршдог. Төр гэдэг бол хийсвэр ойлголт бөгөөд нийтийн эрх, ашгийг хангах, хамгаалах чиг үүргээрээ төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явагдах жамтай. Энэ зарчмын ойлголт нь төрийн байгууллага, албан тушаалтанд холбогдуулан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамгийн их хаалт болдог. Тиймээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг албадлага хэрэгжүүлэхгүйгээр зохион байгуулах нь өөрөө шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд сөргөөр нөлөөлж байдаг. Энэ агуулгаараа төлбөртэй төрийн байгууллага, албан тушаалтанд хэрэглэх албадлагын арга хэмжээ хангалтгүй томъёологдсон. Бусад байгууллагын тухайд төлбөр төлөгчийн банк дахь харилцах болон хадгаламжийн данснаас төлбөр гаргуулах ажиллагааг шууд зохион байгуулдаг бол төлбөртэй төрийн байгууллага, албан тушаалтны данснаас хасалт хийх ажиллагааг практикт тэр бүр зохион байгуулдаггүй.

График 2. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тоон үзүүлэлт



Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгээс харахад 2023 оны 03 дугаар сарын байдлаар улсын төсөвт байгууллагад холбогдох 156 гүйцэтгэх баримт бичгийн төлбөрийн шаардлагуудыг нарийвчлан авч үзвэл ажлаас үндэслэлгүй халагдсан иргэдэд олгох төлбөр 1.1 тэрбум, ажил гүйцэтгэх гэрээ, тендерийн санхүүжилтийн дутуу төлбөр 56.4 тэрбум төгрөг, эрх бүхий албан тушаалтнаас бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс 3.3 тэрбум төгрөгийн хохирол, төлбөрийг үүсгэсэн талаар тоо баримт гарч байна.

Хүснэгт 2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн судалгаа

Д/Д	Ажлаас үндэслэлгүй халагдсан, ажилгүй байсан хугацааны цалин	Бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад учруулсан хохирол	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирол	Гэрээний үүрэг болон ажил гүйцэтгэхтэй холбоотой маргаанаас үүссэн төлбөр	Нийт
Гүйцэтгэх хуудас	92	16	1	44	153
Мөнгөн дүн /төгрөг/	1.147.883.631	3.397.327.858	1.011.437	56.416.337.922	56.416.337.922

Дээрх мэдээллээс харахад төрийн байгууллага, албан тушаалтан ажлаас үндэслэлгүй халсан талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нийт гүйцэтгэх баримт бичгийн 60 орчим хувийг дангаараа эзэлж байна.

График 3. Ажлаас үндэслэлгүй халагдсан тухай шүүхийн шийдвэрийн судалгаа



Ажлаас үндэслэлгүй халагдсан талаарх шүүхийн шийдвэрийг нарийвчлан авч үзэхэд төрийн улс төрийн албан тушаалтан 2%, төрийн тусгай албан хаагч 8%, төрийн үйлчилгээний албан тушаалтан 41%, төрийн захиргааны албан тушаалтан

49%-ийг тус тус эзэлж байна. Үүнээс үзэхэд төрийн захиргааны албанд ажлаас үндэслэлгүй халах явдал хамгийн их байгааг харуулж байна.

Дүгнэлт

Захиргааны эрх зүйд захиргааны байгууллагын шийдвэрийг биелүүлэх болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гэсэн хоёр ойлголт байдаг тухай дээр өгүүлсэн билээ.

Захиргааны байгууллагын шийдвэр биелүүлэх ажиллагаа нь захиргааны ерөнхий хуулийн хүрээнд хэрэгжих бөгөөд шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу албадлагын арга хэмжээг хэрэглэдэг.

Харин захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны хэргийн шүүх ажиллагааны үргэлжлэл бөгөөд эцсийн үр дүн гэж хэлж болох ба уг ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулна.

2002 оны ШШГТХуульд “захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа”-ны тухай захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбоотой 2016 оны 2 сарын 4-ний тогтоолоор нэмэлт бүлэг шинээр орж ирсэн байдаг. Үүнээс өмнө иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас эш татаж хэрэглэдэг байсан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн харилцаа нь тэгш бус эрхтэй талуудын хооронд үүсдэг нийтийн эрх зүйн харилцаа байдаг. Энэ утгаараа захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэл учирдаг байсан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх шинэ хууль батлагдсанаар захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх арга механизмыг тодорхой тусгасан юм.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх шинэ хуулийн зохицуулалттай болсон нь сайн талтай ч хуулийг судлан үзэхэд 128-р зүйлд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрт хяналт тавих механизмыг хуульчилсан боловч хуулийн 128.2 “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан энэ хуульд заасан хугацаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг Засгийн газарт, Улсын Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна” гэж бүрхэг заалт оруулжээ. Энэ нь зөвхөн танилцуулаад орхих уу гэдэг асуудал хөндөгдөж байна. Хуулийн 132.2-т “...шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ” гэж заасан нь бодит байдал дээр

ийм үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулсан тухай мэдээлэл байхгүй байна. Мөн Судалгаанаас харахад шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгч /хариуцагч/ албан тушаалтан нь дээрх хуулийн заалтад байгаа албан тушаалтнууд байгаа юм. Тиймээс дээрх эрх мэдэл бүхий албан тушаалтан шүүхийн шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх тухай нарийн тогтоосон журам гаргах хэрэгтэй байна.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд “Энэ хуулийн зорилт нь төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлсон боловч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг тодорхойлон хуульчлаагүй байна. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд төрийн алба хариуцлагатай байх эрх зүйн үндсийг тогтоох зорилготой атлаа шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй төрийн байгууллага, албан тушаалтанд авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ болон хариуцлагын талаарх ойлголт огт тусгаагүй байгаа нь захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэнд сөргөөр нөлөөлж байна.

Хэрэв Төрийн албаны тухай хуулийн хариуцлагын хэсэгт Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг үе шаттайгаар хуульд тусгаж өгвөл жинхэнэ утгаараа төрийн албаны хариуцлага нэмэгдэж, иргэнийхээ эрх ашгийг хөндөх эрх зүйн зөрчлийн тоо багасах боломжтой юм.

Санал

1. Захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх, төрийн эрх мэдлийн хуваарилалтын тогтолцоог тэнцвэржүүлэх хүрээнд төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүрэгт “Шүүхийн шийдвэрийг биелүүлэх” гэсэн заалтыг нэмж тусгах шаардлагатай. Ингэснээр шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх эрх зүйн үндсийг бэхжүүлнэ.

2. Зөрчлийн тухай хуульд заасан “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” зөрчилд “Захиргааны хэргийн талаар шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн үүргийг биелүүлээгүй нь төрийн албан тушаалтанд зөрчлийн тухай хуулиар зөрчлийн шийтгэл хүлээлгэх үндэслэл болгох.

3. Мөн төсвийн буюу төрийн байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчөөр оролцох тохиолдолд төсвийн байгууллагын дараа жилийн төсөвт тусгуулах зохицуулалтыг дээр дурдсан тул тус зохицуулалтыг бодитой болгох хүрээнд төсвийн тухай хуульд заасан төсвийн зарчимд “Шүүхийн шийдвэрийг нэн тэргүүнд барагдуулах” зарчмыг тусгах. Учир нь Монгол Улсын

Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийн үндсийг гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдэлтэй адилтган тогтоосон хэдий ч гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд шүүхийн шийдвэрийг хэрхэн авч үзэх талаар зарчмын шинжтэй агуулгыг тусгаагүй нь шүүхийн шийдвэр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хоёрдогч ач холбогдолтойд авч үзэхэд хүргэж байна.

4. Онцлог нь захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь төрийн байгууллага, албан тушаалтан цаашлаад төрийн өндөр дээд албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хамаарах тул тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан бие даасан эрх зүйн хэм хэмжээнд шүүхийн шийдвэрийг биелүүлэх зарчмын агуулгыг тусгах шаардлагатай ба ингэснээр Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасан захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдох зохицуулалт нь бодитой хэрэгжих суурь нөхцөлийг хангах боломжтой болно.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

б. Монгол эх сурвалж

7. Г.Банзрагч “Захиргааны процессын эрх зүй” 2019 он
8. А.Дугармаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудал” илтгэл
9. П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” УБ., 2016 он
10. Д.Сүнжид “Захиргааны ерөнхий хууль: үзэл баримтлал, хэрэглээ” УБ., 2017 он
11. Ц.Цогт “Захиргааны эрх зүй” өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл. УБ., 2016 он
12. А.Эрдэнэцогт “Монгол улсын захиргааны процессын эрх зүй” УБ., 2014 он
13. А.Эрдэнэцогт “Монгол улсын захиргааны процессын эрх зүй” УБ., 2022 он

II. Эрх зүйн эх сурвалж

5. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
6. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2002 он
7. Захиргааны ерөнхий хууль. УБ 2016 он
8. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2016 он
9. Захиргааны ерөнхий хуулийн тайлбар. УБ., 2017 он
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2002 он
11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он
12. Зөрчлийн тухай хууль. УБ., 2017 он.
13. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он
14. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль. УБ., 2012 он
15. Төрийн албаны тухай хууль. УБ., 2002 он.

III. Бусад эх сурвалж

1. Төсөл “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхыг бэхжүүлэх” УБ., 2016 он.
2. Гарын авлага “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” УБ., 2004 он.
3. Тайлан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар”. УБ., 2015 он.

---o0o---